

Эрүүл мэндийн газрын 2025 оны
Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн
хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Байгууллагын Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ГТ-ний биелэлт хариуцсан мэргэжилтэн нь байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэсэн болно. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолыг баримтлан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс нь Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээг бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалаар тооцон гаргасан болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 76 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тайлант онд төлөвлөсөн арга хэмжээнүүдээс

58 арга хэмжээ буюу нийт ажлын 76.3%-нь 100 хувийн хэрэгжилттэй;

15 арга хэмжээ буюу 19%-нь 90 хувийн хэрэгжилттэй;

2 арга хэмжээ буюу 2.6%-нь 70 хувийн хэрэгжилттэй;


1 арга хэмжээ буюу 1.3%-нь 50 хувийн хэрэгжилттэй байна.

ЭМГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 97.0% “Бүрэн хангалттай” гэж үнэлэгдэв.

Хүснэгт 1 . Хяналт-шинжилгээний чанарын үзүүлэлт

Үнэлгээ	Арга хэмжээ	
	Тоо	Эзлэх хувь
Төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин 85 буюу түүнээс дээш бол “Бүрэн хангалттай” гэсэн заалт	73	96.1
Төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин 70-85 буюу түүнээс дээш бол “Хангалттай” гэсэн заалт	2	2.6
Төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин 70 хүртэл хувь бол “Хангалттайгүй” гэсэн заалт	1	1.3
Дундаж	97.0 хувь	


Эрүүл мэндийн газрын 2025 оны жилийн эцсийн
Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн эзлэх хувь



Хүснэгт 2. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний
хэрэгжилт (хариуцсан нэгжээр)

№	Хэлтэс	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь			
			100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь
1	УТСХ	34	23	10		1
2	НЭМХ	24	20	3	1	
3	ЭТҮХ	9	6	2	1	
4	ХШҮМХ	6	6			
5	ХХ	3	3			
		76	58	15	2	1

Зураг 2. Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь (хариуцсан нэгжээр)



Дөрөв. Дүгнэлт

Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 97.0 хувийн хэрэгжилттэй "Бүрэн хангалттай" гэж үнэлэгдэж байгаа буюу арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан гэж дүгнэж байна. Төлөвлөгөөнд 76 арга хэмжээ батлагдсанаас 58 арга хэмжээ буюу нийт ажлын 76.3%-нь 100 хувийн хэрэгжилттэй; 15 арга хэмжээ буюу 19,0% нь 90 хувийн хэрэгжилттэй; 2 арга хэмжээ буюу 2.6%-нь 70 хувийн хэрэгжилттэй, 1 арга хэмжээ буюу 1.3%-нь 50 хувийн хэрэгжилттэй байна.

- Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн боловч дүн бүрэн гараагүй /төсөв байхгүй/, хэрэгжилтийг үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна.
- Төлөвлөсөн тодорхой ажлуудыг зохион байгуулсан боловч шалгуур үзүүлэлтэд хүрээгүй 2 арга хэмжээ байна
- Тухайн жилийн төлөвлөлтийг тодорхой болгох, мөн тайлаг оновчтой бичих хэрэгтэй байна.

Тав. Зөвлөмж

1. Эрүүл мэндийн газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад холбогдох бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлох, үндэслэж байгаа бодлогын баримт бичгийн заалтын дугаарыг бичиж тусгах

2. Дээрх бодлогын баримт бичиг, хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэлтсийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан эсэхэд хэлтсийн дарга нар хяналт тавьж ажиллах

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн заалтыг ирэх оны төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийг нарийн тусгах

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа оновчтой, шалгуур үзүүлэлтийн дагуу товч, тодорхой, үр дүнг тусгаж тайлагнаж хэвших

Мэдээлэл хариуцагч: Мэргэжилтэн Б.Гантулга

Имэйл хаяг: b.gantulga@bu.moh.gov.mn

Утас: 99442404